



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 09 сарын 28 өдөр

Дугаар А/648.

Мөрөн

Эрх шилжүүлэх тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.3 дахь заалт, аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн ээлжит III хуралдааны 3 дугаар тогтоол, аймгийн ИТХ-ын 2017 оны 05 дугаар сарын 10-ны өдрийн ээлжит бус IV хуралдааны 1 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн ИТХ-ын 2017 оны ээлжит III хуралдааны 3-р тогтоолын 08 дугаар хавсралтын "Хөгжлийн хөтөч" хөтөлбөрөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын "Мөрөн сумын хүндэтгэлийн хаалга орчимд тохижилт хийх" 20,0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажил, аймгийн ИТХ-ын 2017 оны ээлжит бус IV хуралдааны 01 дүгээр тогтоолын 7 дугаар хавсралтын хуш модны самрын орлогоос байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар санхүүжих төсөл арга хэмжээний жагсаалтын "Хашаа" хөтөлбөрийг хэрэгжүүлэх 10,0 сая төгрөгийн ажлын гүйцэтгэгчийг цахим тендер шалгаруулалтын аргаар сонгож, гэрээ байгуулах эрхийг Мөрөн сумын Засаг даргад шилжүүлсүгэй.

2. Худалдан авах ажиллагааг зохион байгуулсан тухай тайлан мэдээг 2017 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор ирүүлэхийг Мөрөн сумын Засаг дарга /Ц.Гансүх/-д даалгасугай.

3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Орон нутгийн өмчийн газрын дарга /Б.Болд/-д үүрэг болгосугай.

ДАРГА



Л.ГАНБОЛД